


АЙМГИЙН ЭДИЙН ЗАСАГ-НИЙГМИЙН БАЙДЛЫН 2011 ОНЫ МЭДЭЭЛЭЛ

Мал тооллого: Аймаг мал сүргээ 95.9 хувиар онд оруулж, 581.4 мянган төл 93.5 хувиар бойжуулж, өмнөх оноос мал өсч, бүгд нэг сая 613.3 мянган толгой мал тоолууллаа. Үүнд: тэмээ 25.2 мянга, адуу 46.5 мянга, үхэр 22.1 мянга, хонь 461.7 мянга, ямаа нэг сая 57.8 мянган толгой байна. Тухайлбал: нийт мал 297.8 мянгаар, үүнээс тэмээ 0.9 мянгаар, адуу 7.8 мянгаар, үхэр 3.7 мянгаар, хонь 65.4 мянгаар, ямаа 220.0 мянгаар тус тус өслөө. Бүх сум нийт малаа, Дарив, Жаргалан, Тайшир, Тонхил, Эрдэнэ сумдаас бусад сумд таван төрөл дээр нь өсгөжээ. Дээрхи 5 сум тэмээг 7-96-гаар, Эрдэнэ сум хонио 0.7 мянгаар тус тус бууруулсан дүн гарлаа.



Мөн мянгат малчдын тоо өмнөх оноос 75.9 хувиар өсч одоо аймагт мянгат малчин 51 байгаагийн дотор 2001-ээс дээш малтай өрх 4, 1500-2000 малтай өрх 4, 1000-1499 малтай өрх 43 боллоо. Оны эцсийн байдлаар 100-аас дээш мянган толгой малтай 6, 90-ээс дээш мянган толгой малтай 1, 80-аас дээш мянган толгой малтай 6, 60-аас дээш мянган толгой малтай 2, 50-иас дээш мянган толгой малтай 1, 40-өөс дээш мянган толгой малтай 2 сум байна. Нийт мал болон ямааны тоогоор Цогт сум, тэмээгээр Төгрөг сум, адуугаар болон хониор Тонхил сум, үхрээр Халиун сум аймагтаа тэргүүлж байна.

Хээлтэгч мал, 100 эхийн төл: Хээлтэгч мал өмнөх оноос 2.7 хувиар буурч, оны эцсийн байдлаар төллөх насны хээлтэгч 665.8 мянга болж, нийт малын 41.3 хувь, тухайн сүргийн дотор ингэ 32.0, гүү 29.9, үнээ 45.6, эм хонь 43.1, эм ямаа 41.1 хувийг тус тус эзэлж байна.



Аймгийн дүнгээр оны эхний төллөх 100 эхээс ишиг, хурга 86, тугал 70, унага 69, ээлжийн ингэнээс ботго 45-ыг тус тус бойжуулав. Мөн тайлант онд 25.5 мянган хээлтэгч мал хээл хаяж, 58.2 мянган хээлтэгч мал сувайрсан байна.

Цэвэр, эрлийз, нутгийн шилдэг омгийн мал: 2011 оны эцэст шилдэг омгийн тэмээ 6.2 мянга, сайжруулсан тэмээ 0.1 мянга, шилдэг омгийн адуу 122, сайжруулсан адуу 120, цэвэр үүлдрийн үхэр 26, эрлийз үхэр 65, цэвэр үүлдрийн хонь 69.1 мянга, сайжруулсан хонь 1.7 мянга,


шилдэг омгийн хонь 0.7 мянга, цэвэр үүлдрийн ямаа 69.3 мянга, сайжруулсан ямаа 23.0 мянга, шилдэг омгийн ямаа 2.7 мянга бүгд 173.0 мянган мал тоологдлоо.

Иргэдийн мал: Иргэд нэг сая 609.8 мянган толгой мал тоолуулсан нь аймгийн нийт малын 99.8 хувийг эзэлж байна. Аминдаа малтай 9.2 мянган өрх байгаагийн 7.0 мянга нь малаа байнга малладаг малчин өрх байна. Энэ жилийн байдлаар малтай нэг өрхөд бодод шилжүүлснээр 34 бод буюу 174 толгой мал, малчин нэг өрхөд бодод шилжүүлснээр 40 бод буюу 203 толгой мал ногдож байна.


Иргэдийн хувийн малын бүлэглэлтээс харахад 10 хүртэл толгой малтай 270 өрх, 11-30 толгой малтай 895, 31-50 толгой малтай 862, 51-100 толгой малтай 1744, 101-200 толгой малтай 2614, 201-500 толгой малтай 2402, 501-999 толгой малтай 408 өрх байна.



Малчдын соёл ахуйн зарим үзүүлэлт: Аймгийн нийт малчид жилийн дөрвөн улирлын аясаар нүүдэллэж, бэлчээрийн мал аж ахуйгаа маллах явцад соёл ахуйгаа дээшлүүлсээр ирлээ. Тухайлбал: цахилгааны эх үүсгүүртэй өрх 6.9 мянга, телевизортой өрх 6.4 мянга байна. Мөн 2.6 мянган өрх 2.6 мянган авто машин, 4.6 мянган өрх 4.8 мянган мотоцикль, 40 өрх 50 тракторыг ажил амьдралынхаа хэрэгцээнд ашиглаж байгаа нь өнгөрсөн оныхоос тракторын тоо 14, телевизортой өрх 114, машинтай өрх 78, мотоцикльтай өрх 359-өөр өссөн байна. Тайлант онд малчид 0.9 мянган метр эсгий хийж гэрийн бүрээсээ шинэчлэх, шинэ гэр барихдаа зориулсан байна. Малчин өрхүүдээс өөрийн эзэмшлийн худагтай өрх 1.4 мянга, хашаатай өрх 4.7 мянга байна.



ХАА-н тэжээвэр амьтад: Аймагт ХАА-н тэжээвэр амьтад өсгөн үржүүлж, хэрэгцээндээ ашиглаж байгаа өрх 72 болж, гахайн мах 1.8 тн, өндөг 6.0 мянган ширхэгийг үйлдвэрлэж, өөрийн хэрэгцээндээ болон зах зээлд нийлүүлэв. Оны эцэст илжиг 101, гахай 38, тахиа 2.8 мянга, тахь 48 тоологдлоо.



Шинээр гаргасан, засварласан худаг: Энэ онд 196.8 сая төгрөгийн хөрөнгө бүхий инженерийн хийцтэй 20, энгийн уурхайн 28 бүгд 48 худаг шинээр гаргаж, 99 худгийг 60.0 сая төгрөгөөр засварлан ашиглажээ.

Малжуулалтын талаар: Энэ онд 270 өрхийг малжуулалтанд хамруулж бод, бог нийлсэн 10.8 мянган толгой малтай болгоход олон улсын хөтөлбөр, төслөөс 57.0 сая, орон нутаг болон малчдаас 448.4 сая бүгд 505.4 сая төгрөгийг зарцуулсан байна.

Малын тэжээл бэлтгэл: Энэ жил 5965.6 тонн байгалийн хадлан, 203.8 тонн гар тэжээл тус тус бэлтгэлээ. Зарим сум төмс, хүнсний ногоо, үр тарианы хаягдал, сүрэл, хужир шүү зэргийг малдаа бэлтгэж нөөцөлсөн байна.

Ургац хураалт: Энэ оны эцсийн байдлаар үр тариа 831.2 тн, үүнээс улаан буудай 522.0 тн, төмс 1503.1 тн, хүнсний ногоо 804.7 тн, малын тэжээлийн ургамал 1685.0 тн, жимс жимсгэнэ 53.0 тонныг тус тус хурааж аваад байна. Га-гаас үр тариа 13.2, төмс 66.2, хүнсний ногоо 53.5, тэжээлийн ургамал 26.9, жимс жимсгэнэ 13.6 цн-ийг тус тус хураажээ.



Аймгийн Хөдөө аж ахуй, жижиг дунд үйлдвэрийн газар:

Энэ онд аймгийн хэмжээгээр 958.0 мянган малыг халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд хамруулахаас 968.0 мянган малыг хамруулж биелэлт 101.0 хувьтайгаас гадна энэ онд баруун бүсийн бүх малыг бруцеллэз өвчнөөс сэргийлэх ажлын хүрээнд бог 1690.0 мянга, үхэр 22.0 мянга, бүгд 1712.0 мянган мал хамрагдлаа. Мал амьтныг паразиттах өвчнөөс эмчлэн сэргийлэх арга хэмжээнд 1870.0 мянган малыг хамруулж, 664.1 мянган малд боловсруулалт, 723.9 мянган мал, амьтанд туулгалт, 482.0 мянган малд угаалга хийлээ. 2011 онд тус аймагт мал амьтны халдварт өвчнөөс боом, шөвөг яр, сохор догол, галзуу, адууны томуу, цусан халдвар, сахуу зэрэг 7 төрлийн халдварт өвчин гарч 859 мал, амьтан өвчилж 10 мал хорогдлоо.

“Үхэр, хонь, ямааны бруцеллэз өвчинтэй тэмцэх” төслийн хүрээнд тухайн онд аймгийн хээлтүүлэгч малд шинжилгээ хийх ажлыг зохион байгуулж, 297 буур, 326 бух, 2598 хуц, 3711 ухна, бүгд 6932 малыг хамрууллаа. Шинжилгээгээр өвчтэй хээлтүүлэгч илрээгүй байна.

Шүлхийн тандах шинжилгээнд улсын хил, төв зам дагуу 9 сумын 22 багийн 25 өрхийн 1500 малыг хамруулан тандах шинжилгээг хийхэд эерэг болон сэжигтэй малгүй, уг өвчнөөр тайван байна.

Малын бруцеллэз, ям, сүрьеэ, лейкоз, адууны халдварт цус багадах болон шинээр гарч буй зарим өвчний тандах шинжилгээнд 18 сумын 57 багийн 5 төрлийн бүгд 9228 малаас арга зүйн дагуу дээж авлаа. Уг дээжинд Мал эмнэлгийн хүрээлэнтэй хамтран шинжилгээг хийлээ.

Шинжилгээний дүнгээр 6708 малын /адуунаас бусад 4 төрлийн/ дээжинд бруцеллэзийн шинжилгээг хийхэд 35 малд эерэг урвал үзүүлээ. Үүнд хонь 9, ямаа 23, тэмээ 2, үхэр 1 байна.

Шинжлэгдсэн малын 0.5 хувь нь эерэг дүнтэй байна. Адууны ям, халдварт цус багадах өвчин, үхрийн сүрьеэ, лейкоз өвчнөөр тайван дүн үзүүлж байна.

Байгаль орчны алба: Энэ онд "Ойн зурвас" байгуулах ажлын хүрээнд 25 га-д ойжуулалтын ажил гүйцэтгэснийг 79.3%-ийн амьдралтайгаар, "Ногоон хэрэм" үндэсний хөтөлбөрийн хүрээнд 15 га-д мод тарьсныг 80.0 хувийн амьдралтайгаар хүлээн авчээ.

2011 онд 17 төсөлд байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээ хийлгэхэд 5 төсөлд шууд хэрэгжүүлэх, 8 төсөлд нөхцөл болзолтойгоор хэрэгжүүлэх, 4 төсөлд нарийвчилсан үнэлгээ хийлгэх дүгнэлт гаргаж өгсөн байна.

Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар: 2011 онд 417 иргэнд 34.5 га газрыг гэр бүлийн хэрэгцээнд зориулан үнэгүй өмчлүүлсэн ба одоо эзэмшиж, ашиглаж байгаа хашааны газарт 155 иргэнд 13.8 га газрыг, шинэ нэгж талбар газарт 262 иргэнд 22.0 га газрыг өмчлүүлсэн байна. Аж ахуйн зориулалтаар 1 иргэнд 40.0 м² газрыг үнээр нь худалдаж өмчлүүлжээ. Өссөн дүнгээр аймгийн хэмжээнд 4194 иргэнд 424.9 га газрыг өмчлүүлсэн байна.

Аймгийн Аудитын газар: 2011 онд 184 байгууллагад санхүүгийн тайлангийн аудит, 80 байгууллагыг хамруулан 27 гүйцэтгэлийн аудит, 10 байгууллагыг хамруулан 1 байгаль орчны аудит, 23 байгууллагыг хамруулан 23 эрсдлийн аудит хийлээ. Аудитаар 5.5 тэрбум төгрөгийн зөрчил илрүүлж 172 заалт бүхий зөвлөмж, 177 заалт бүхий шаардлага өгч 62.7 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож гаргасан шийдвэрийн хэрэгжилтийг хангуулах ажлыг зохион байгуулан ажиллажээ. Энэ арга хэмжээний үр дүнд тавьсан актны 71.5 хувь, өгсөн шаардлагын 87.0 хувь, хугацаа болсон зөвлөмжийн 92.3 хувь биелж орон нутгийн төсөвт үйлчилгээний төлбөрөөр 36.3 сая төгрөг, хүү торгуулийн орлогоор 44.8 сая төгрөг оруулсан байна.

Стандартчилал, хэмжил зүйн хэлтэс: Хэмжүүрийн лаборатори хүнд, эзэлхүүн багтаамж, цахилгаан, нягт, даралтын хэмжлийн төрлөөр үйлдвэрлэл, үйлчилгээ, эмчилгээ, худалдаа эрхлэгч 451 ахуй нэгж, иргэний 2375 ширхэг хэмжүүр хэмжих хэрэгслийг улсын шалгалт баталгаажуулалтанд хамруулсан байна.

29 нэрийн 285 ширхэг савласан бүтээгдэхүүний тоон хэмжээнд хяналт, шалгалт хийж гарсан зөрчил дутагдлыг арилгуулж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгчээ.

Баталгаажуулалтын алба Засгийн газрын 2005 оны 127-р тогтоолоор батлагдсан "Чанарын баталгаажуулалтанд заавал хамруулах бүтээгдэхүүн, үйлчилгээний жагсаалтанд орсон 65 бүтээгдэхүүн, ажил үйлчилгээнд тохирлын үнэлгээ явуулж, чанар стандартын шаардлага хангасан 118 үйлчилгээ, 13 аж ахуй нэгжийн 10 нэрийн 26 бүтээгдэхүүнд "Тохирлын гэрчилгээ" олгожээ.


Сорилтын лаборатори 87 нэрийн /давхардсан тоогоор/ 385 дээжийн 1540 үзүүлэлтэнд сорилт шинжилгээ хийж, зөрчилтэй гарсан 5 нэрийн 19 бүтээгдэхүүний эздэд нь зөвлөгөө өгч зөрчлийг арилгуулснаас гадна үйлдвэрүүдийн лабораторийн ажилтай танилцаж шаардлагатай урвалж бодис, нэрмэл ус, шинжилгээний аргын стандартыг бэлтгэн өгч тусалсан байна. СХЗГ-н стандарт, мэдээлэл лавлагааны төвөөс шинээр батлагдсан болон шинэчлэгдсэн стандартыг цахим хэлбэрээр захиалан авч 118 аж ахуйн нэгж, 395 иргэнд 412 стандартаар үйлчилжээ.

Төсвийн орлого: Аймаг, сумдын татвар, санхүүгийн байгууллагынхан төсвийн орлогын талаар нилээд шахуу дайчин ажилласны дүнд улс, орон нутгийн төсвийн орлогод бүгд 7 тэрбум 877.8 сая төгрөг оруулж, төлөвлөгөөг 120.6 хувиар биелүүлэв. Үүнээс улсын төвлөрсөн төсвийн орлогод 589.6 сая төгрөг оруулж, төлөвлөгөөг 105.6 хувиар, орон нутгийн төсвийн орлогод 7 тэрбум 288.2 сая төгрөг оруулж, төлөвлөгөөг 122.0 хувиар биелүүллээ.

Төсвийн зарлага: Төсвийн зарлагын нэгдсэн дүнгээр 32 тэрбум 924.1 сая төгрөгийн санхүүжилт хийж, зарлага санхүүжилтын төлөвлөгөөг 98.6 хувиар биелүүлсний дотор цалин, нэмэгдэл урамшуулал, унаа, хоолны хөнгөлөлтийн төлөвлөгөөний 98.6 хувийг, нийгмийн даатгалын шимтгэлийн төлөвлөгөөний 97.9 хувийг, бараа үйлчилгээ бусад зардал 96.9 хувиар, нэг удаагийн тэтгэмж, урамшууллын төлөвлөгөөг 117.5 хувиар, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний 100.3 хувийг тус тус санхүүжүүллээ. Улс, орон нутгийн төсвийн байгууллагууд нь энэ онд 10.8 сая төгрөгийн өртэй байгаагийн 48.1 хувийг нийтийн ерөнхий үйлчилгээ, 34.9 хувийг соёлын салбар, 13.4 хувийг эрүүл мэндийн салбар эзэлж байна. Төсвийн байгууллагууд 30.1 сая төгрөгийн авлагатай гарч, авлагын 63.9 хувь нь нийтийн ерөнхий үйлчилгээний авлага, 17.9 хувь нь боловсролын салбарын авлага эзэлж байна.

Банкны мөнгөн орлого, зарлага: Бүгд 36 тэрбум 126.5 сая төгрөгийн зузаатгал хийж кассын гүйлгээнээс 205 тэрбум 695.0 сая төгрөг татаж, монгол банкинд 25 тэрбум 123.1 сая төгрөг шилжүүлж, гүйлгээнд 249 тэрбум 113.3 сая төгрөг гаргалаа. Зээлийн өрийн бүх үлдэгдэл 35 тэрбум 163.4 сая төгрөг болж хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл 36.3 сая төгрөг байна. Иргэдийн хадгаламж өнгөрсөн оны энэ үеэс 35.7 хувиар өссөн байна.

Аж үйлдвэр: Тайлант хугацаанд Алтай-Улиастай, Мандал голомт, Тулга-Алтай, Говь-Гоулд, Ентүм, Ундрам-Оюу, Шимт дээж, Ундарга-Алтай, Баярт олон, Удмын ундраа, Мандал хүдэр зэрэг 129 аж ахуйн нэгж байгууллага үйлдвэрлэл явууллаа. Аймгийн дүнгээр энэ салбарт 13 тэрбум 870.8 сая төгрөгийн нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэж, 7 тэрбум 293.2 сая төгрөгийн бүтээгдэхүүн борлууллаа. Аж үйлдвэрийн салбарт үйлдвэрлэсэн болон борлуулсан бүтээгдэхүүний 88.1 хувийг цахилгаан, дулаан, усан хангамж эзэлж байна. Одоогоор тус салбарын нийт бүтээгдэхүүний 87.3, мөн борлуулалтын 86.4 хувийг аймгийн төвд, үлдэх хувийг сумдад үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн эзэлж байна



Гол нэрийн бүтээгдэхүүнээс цахилгаан, дулаан, түгээсэн ус, сувагжуулалт, гутал, талх, нарийн боовны үйлдвэрлэл өнгөрсөн оны мөн үеэс 0.01-2 дахин нэмэгдлээ. Харин нүүрс олборлолт, оёдол, хиам, архи дарс, ус, ундаа үйлдвэрлэлт өмнөх оноос буурчээ.

Зам, барилга: Барилга угсралтын ажлыг 22 компани гүйцэтгэж 4 тэрбум 917.4 сая төгрөгөөр 15 шинэ барилга объект, мөн Ус-Алтай ХХК нь 11 шинэ худгийг тус тус барьж ашиглалтанд оруулжээ. Барилгын их засварын ажлыг 14 компани гүйцэтгэж 21 барилгад 1 тэрбум 110.3 сая төгрөгийн ажил хийжээ. Есөнбулаг сумд 20 айлын орон сууцыг “Тулга-Алтай” ХХК, Жаргалант багийн халуун усыг “Алтай өргөө” ХХК, 15 айлын орон сууцыг “Айргийн хад” ХХК, Алтай сумын сургуулийн халуун усыг “Орд харш” ХХК, шатахуун түгээх станцыг “Харшийн цуурай” ХХК, Төгрөг сумын 160 хүүхдийн суудалтай сургуулийн өргөтгөлийг “Шатат” ХХК, Говь-Алтай аймгийн Татварын хэлтсийн конторыг “Арвин сүлжээ” ХХК, Бугат сумын Говийн их дархан цаазат газрын Б бүсийн байрыг “Арвижих ундарга” хоршоо, Цогт сумын Баян-Улаан багийн контор, Говийн их дархан цаазат газрын байгаль хамгаалагчдын байрыг “Харшийн цуурай” ХХК, Эрдэнэ, Цээл сумын цагдаагийн кабон “Айргийн хад” ХХК шинээр ашиглалтанд өгсөн байна.

2011 онд барилгын компаниуд барилга угсралт, их засварын нийт 6 тэрбум 27.7 сая төгрөгийн ажил хийж гүйцэтгэв.

Авто тээвэр: Авто тээврийн байгууллага зорчигч, ачаа тээвэрээр байгууллага, иргэдэд үйлчилж 38.4 сая төгрөгийн орлоготой ажиллав.

Петровис-Ник ХХК: Арван хоёр тэрбум 901.5 сая төгрөгийн шатахуун, шатах тослох материалын борлуулалт хийсэн байна.

Мон сүль ХХК: Хоёр тэрбум 18.3 сая төгрөгийн шатахуун, шатах тослох материалын татан авалт хийж, нэг тэрбум 894.0 сая төгрөгийн борлуулалт хийсэн байна.

Цахилгаан холбооны газар: 0.8 мянган телефон цэг, 3 таксафоноор байгууллага иргэдэд үйлчилж 176.5 сая төгрөгийн орлоготой ажиллав. Мөн интернэтийн үйлчилгээний 1 цэг 10-н суудалтай ажиллаж интернэтээр дунджаар 8.3 мянган хүнд үйлчилж, 510 хэрэглэгч байнгын үйлчлүүлэгч болжээ. Хөдөлгөөнт утасгүй телефоны үйлчилгээ 0.2 мянган хэрэглэгчтэй байна.

Шуудан үйлчилгээний газар: Хэвлэл захиалга, мөн хэвлэл хүргэх болон шуудан, зорчигч тээвэрээр сум, хот хооронд үйлчилж 67.2 сая төгрөгийн орлоготой ажиллав.

Олон нийтийн Алтай радио: Энэ онд нийт 74 удаагийн нэвтрүүлэг бэлтгэн цацаж 2.8 сая төгрөгийн орлого олжээ.

Миний нутаг телевиз: Мэдээ, сонины тоймыг 210 цаг, уран сайхны болон хүүхэлдэйн киног 1000 цаг, захиалгат нэвтрүүлгийг 18 цаг, шууд нэвтрүүлгийг 24 цаг, зар сурталчилгааг 108 цаг нийтэд цацан мэдээлсэн байна.

Зэрэглээт-Алтай ХХК: Алтай хотын хүн амд нийт 16 сувгийн телевизийн нэвтрүүлгийг цацаж, 3.2 сая төгрөгийн орлоготой ажиллаж 385 өрхөд кабелийн телевизийн нэвтрүүлгээр үйлчилж байна.

Мобиком корпорацийн Говь-Алтай дахь салбар: Тус салбарын дараа төлбөрт хэрэглэгч 0.9 мянга, мобикарт эзэмшигч 15.6 мянга нийт хэрэглэгч 16.5 мянгад хүрчээ.


Юнител ХХК-ний Говь-Алтай дахь салбар: Тус салбар үндсэн хэрэглэгч 0.2 мянга, картын хэрэглэгч 9,5 бүгд 9.7 мянган хэрэглэгчтэй болсон байна.

Ж-Мобайл: Тус салбар нь дараа төлбөрт хэрэглэгч 0.8 мянга, урьдчилсан төлбөрт хэрэглэгч 14.8 мянга, нийт 15.6 мянган хэрэглэгчтэй болж 11 сум, сууринд сүлжээгээ оруулжээ.

Хилийн худалдаа: Бургастайн боомтоор зургаан удаа хилийн худалдаа хийж 108.4 сая ам.долларын тэмрийн хүдрийн баяжмал гаргаж, дугуйт ачигч, конвейер, сеператор, цемент, бусад тоног төхөөрөмж зэрэг 20.1 сая ам.долларын бараа материал оруулж ирэв.

Үнэ: хэрэглээний бараа бүтээгдэхүүний индекс суурь үеийн үнэтэй харьцуулахад 91.5 хувиар, өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 18.0 хувиар өссөн байна.

Сарууд		1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
Нэг кг ноолуур	2010	20	31.	35.	38.	41.	49.	54.	52.	51.	46.	45.	45.
ЫН ҮНЭ төгрөг	2011	45	45.	47.	66.	55.	52.	53.	54.	55.	56.	50.	45.




Нийгмийн даатгалын хэлтэс: Нийгмийн даатгалын шимтгэлээр 3 тэрбум 512.0 сая төгрөг, тэтгэврийн санхүүжилтээр 4 тэрбум 128.0 сая төгрөг, бүгд 7 тэрбум 640.0 сая төгрөгийн эх үүсвэр төвлөрүүлж, 5.9 мянган хүний 7 тэрбум 904.0 сая төгрөгийн тэтгэврийг бүрэн олголоо. Мөн тэтгэмжинд олговол зохих 459.5 сая төгрөг, үйлдвэрийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалын 314.8 сая төгрөгийг тус тус олгосон байна.

Мэргэжлийн хяналтын газар: Тус газар давхардсан тоогоор 1411 байгууллага, 775 нэгж объект, 21.0 мянган хүний худалдаа үйлдвэрлэл, үйлчилгээний үйл ажиллагааг хамарсан мэргэжлийн хяналт шалгалт хийж, 3.8 мянган зөрчил илрүүлсний 87.6 хувийг арилгуулсан байна. Эдгээр зөрчилд 17.9 сая төгрөгийн торгууль тавьж, 100.0 хувийг барагдуулан, гаргасан дүгнэлт, акт, албан шаардлагынхаа 94.5 хувийг хэрэгжүүлжээ. Нийт 6 байгууллагын үйл ажиллагааг бүрэн, 19 байгууллагын үйл ажиллагааг түр зогсоож, илэрсэн зөрчлийг арилгасан 5 байгууллагын үйл ажиллагааг сэргээсэн байна. Тайлант онд 127 байгууллагын санхүүгийн баримтанд шалгалт хийж 60.6 сая төгрөгийн акт тавьснаас 56.1 сая төгрөгийн буюу 92.5


хувийг барагдуулаад байна. Шалгалтаар илрэн хураагдсан 626.0 мянган төгрөгийн 0.3 мянган ширхэг эд зүйлсийг улсын орлогод оруулжээ.

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэс: Энэ онд хөдөлмөр эрхлэхийг хүсч бүртгүүлсэн ажилгүйчүүд 812 байгаагийн 52.7 хувь буюу 428 нь эмэгтэйчүүд, 68.6 хувь буюу 557 нь 35 хүртэлх насны залуучууд байна. Эдгээр бүртгүүлсэн ажилгүйчүүдийн 152 нь дээд, 54 нь тусгай дунд, 262 нь бүрэн дунд, 157 нь бүрэн бус дунд, 77 нь мэргэжлийн анхан шатны, 90 нь бага, 20 нь ямар ч боловсролгүй хүмүүс байна. Ажилгүйдлийн тэтгэмжийг 66 хүнд 44.7 сая төгрөг олгож, 249 ажлын байр гаргасан иргэдэд арилжааны банкаар 211.2 сая төгрөгийн зээл олгуулсан байна. Мөн ахмад настны болон хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст үзүүлэх хөнгөлөлт, жирэмсэн болон амаржсан, хүүхэд асарсан, хүүхэд үрчилж авч өсгөсөн, ихэр ба өнчин хүүхэд өсгөсөн, хөгжлийн бэрхшээлтэй 18 хүртэл насны хүүхэд, насанд хүрэгчдэд олгох халамж, байнгын асаргаа шаардлагатай иргэн, ахмад настны хөнгөлөлт, тусламж нийт 6.9 мянган хүнд хоёр тэрбум 164.4 сая төгрөгийн халамжийн тэтгэвэр тэтгэмж олгожээ. Мөн алдарт эхийн одонтой 4.9 мянган ээжид 840.2 сая төгрөг, алдар цолтой 69 ахмадад 58.2 сая төгрөгийг тус тус олгожээ. Хүний хөгжлийн сангаас 56.9 мянган хүнд 6 тэрбум 972.8 сая төгрөгийг олгосон байна.

Хүн ам, нийгмийн зарим үзүүлэлт: Оны эцсийн байдлаар 15.5 мянган өрхөд 55.5 мянган хүн амьдарч байгаагийн 49.2 хувь буюу 27.3 мянга нь эрэгтэйчүүд, 50.8 хувь буюу 28.2 мянга нь эмэгтэйчүүд байна.



Нийт хүн амын 32.3 хувь буюу 17.9 мянга нь аймгийн төв Алтай хотод, 15.1 хувь нь сумын төвд, 2.5 хувь нь тосгонд, 52.0 хувь нь хөдөө амьдарч байна.



Аймгийн дүнгээр бүтэн өнчин 97 хүүхэд, хагас өнчин 1.1 мянган хүүхэд, хүүхэдтэй гэр бүлгүй хүн 0.8 мянга, ганц бие өндөр настан өрх 0.8 мянга, өрх толгойлсон 2.8 мянга, хөгжлийн бэрхшээлтэй 1.6 мянган хүн тус тус байна. Нийт хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн 17.7 хувь нь хөдөлгөөний согогтой, 14.7 хувь нь оюун ухааны хомсдолтой, 13.0 хувь нь сонсгол, хэл ярианы согогтой, 10.3 хувь нь хавсарсан согогтой, 11.3 хувь нь харах эрхтний өөрчлөлттэй, 8.6 хувь нь сэтгэцийн эмгэгтэй, 30.4 хувь нь бусад эрхтний бэрхшээлтэй хүмүүс байна. Үүнээс үзэхэд оны эцэст байгаа суурин хүний 2.8 хувь нь дээр дурьдсан ямар нэгэн согогтой, 0-16 насны хүүхдийн 6.1 хувь нь бүтэн болон хагас өнчин амьдарч байна.

Хүн ам өрхийн тоог сүүлийн 5 жилээр харуулбал:



Ажил эрхлэлт, ажилгүйдэл: Аймагт хөдөлмөрийн насны 34.4 мянган хүн байна. 23.9 мянган ажиллах хүч байгаагийн 96.6 хувь нь ямар нэгэн ажил эрхэлж, 3.4 хувь нь хөдөлмөр эрхлэлтийн албанд бүртгэлтэй ажилгүйчүүд байна. Ажилгүйдлийн түвшин 3.4 хувь, ажил

эрхлэлтийн түвшин 67.1 хувьтай гарлаа. Хөдөлмөрийн насны нийт хүн амын 10.5 хувь нь ажил эрхлээгүй, 3.0 хувь нь хөдөлмөрийн чадваргүй хүн байна.

Төрөлт, нас баралт, өвчлөл: Энэ онд 1310 эх амаржиж, 1315 хүүхэд амьд төрж, 304 хүн нас барсан байна. Эхийн эндээгдэл 1, 0-1 хүртэлх насны хүүхдийн эндээгдэл 32, 1-5 хүртэлх насны хүүхдийн эндээгдлийн 2 тохиолдол тус тус бүртгээгджээ. Бүртгээгдсэн нийт халдварт өвчний 950 тохиолдол байгаа ба үүнээс гепатитын 317 тохиолдол бүртгээгдсэн нь 10000 хүн амд 56.4 промилл, бэлгийн замаар дамжих халдварт өвчний 244 тохиолдол бүртгээгдсэн нь 10000 хүн амд 43.7 промилл, цусан суулгын 13 тохиолдол бүртгээгдсэн нь 10000 хүн амд 2.3 промилл, сүрьеэгийн 21 тохиолдол бүртгээгдсэн нь 10000 хүн амд 3.8 промилл, гар, хөл амны өвчний 37 тохиолдол бүртгээгдсэн нь 10000 хүн амд 6.6 промилл байна. Тайлант онд хорт хавдрын 96 тохиолдол бүртгээгдэж уг өвчнөөр 84 хүн нас баржээ. Осол гэмтлийн 669 тохиолдол бүртгээгдэж үүний улмаас 42 хүн нас барсан байна. Тайлант онд эрүүл мэндийн байгууллагын эмч мэргэжилтнүүд нийт 266.8 мянган хүнд үзлэг хийж, 14.7 мянган хүнийг хэвтүүлэн эмчилж, 113.1 мянган ор хоног ашиглалаа. Энэ онд 76.7 мянган хүнийг урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулан 17.1 мянган хүнийг идэвхитэй хяналтанд авч үйлчилсэн байна. Мөн 18.3 мянган удаа түргэн тусламжийн дуудлагад үйлчилсний 3.2 мянга нь алсын дуудлагад үйлчилжээ.

Ерөнхий боловсролын сургуулиуд: Ерөнхий боловсролын 28 сургууль, 27 цэцэрлэгт өсвөр үеийг сурган хүмүүжүүлж байна. Эдгээр сургуулиудад нийт 12.0 мянган суралцагсад байгаагийн 1.1 мянга нь 1 дүгээр ангид, 0.8 мянга нь 10 дугаар ангид элсэж, цэцэрлэгт 3.9 мянган хүүхэд хүмүүжиж байна. Ерөнхий боловсролын сургуулиудад 1.3 мянган ажиллагсад, үүнээс багш 0.7 мянга, цэцэрлэгүүдэд 0.4 мянган ажиллагсад, үүнээс 0.1 мянган багш ажиллаж байна.

Анагаах ухааны коллеж: Нийт ажиллагсад 86, үүнээс багш 56, есөн мэргэжлээр 1356 оюутантай хичээллэж, төгсөх курсэд 354 оюутан суралцаж байна.

Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв: Энэ хичээлийн жилд 16 мэргэжлээр 840 хүүхэд суралцаж, 77 ажиллагсад, үүнээс мэргэжлийн 38, ерөнхий боловсролын 54 багштай ажиллаж байна. 16 мэргэжлээр нийт 209 хүнд мэргэжил олгож төгсгөсөн байна. Дотуур байранд 180 хүүхэд амьдарч байна.

Батлан хамгаалахад Туслах нийгэмлэг: Авто машины жолоочийн дамжаагаар 108 хүнийг “В”, 18 хүнийг “ВС” ангиллын жолооч мэргэжилтэй болгов.

Шинээр буудлагын дугуйлан хичээллүүлж 18 хүүхэд хамрагдаад байна.

“Тэгш-Алтай” ХХК: Жолооч бэлтгэх дамжаагаар 98 хүнд “В” ангиллын жолооч мэргэжил эзэмшүүллээ.

“Ихэс-Алтай” ХХК: Авто машины жолоочийн дамжаагаар 61 хүнд “В” ангиллын жолооч мэргэжил эзэмшүүлэв.

“Хан бүүрал” ХХК: Жолооч бэлтгэх дамжаагаар 69 хүнд “В” ангиллын, 37 хүнд “ВС” ангиллын жолооч мэргэжил эзэмшүүллээ.

Хүүхдийн төлөө хэлтэс: 2010-2011 оны хичээлийн жилд 10 дугуйланд 260 гаруй хүүхэд бүртгүүлэн хичээллэж байна. Хүнд нөхцөлд амьдарч байгаа болон эмчилгээ, мэс засал хийлгэх шаардлагатай, 24 хүүхдэд аймгийн Хүүхдийн төлөө сан болон байгууллагаасаа 1230.0 мянган төгрөгийн тусламж, дэмжлэг үзүүлж, амжиргааны түвшингээс доогуур орлоготой гэр оронгүй хүнд нөхцөлд амьдарч байгаа 3 өрхөд Дэлхийн зөн ОНХХ-өөс гэр олгуулж аюулгүй орчинг бүрдүүллээ.

Үе тэнгийнхнийгээ сурлага урлаг, спортоор манлайлсан хүүхдүүдийг МХТГазрын “Авьяас” медалиар 7 хүүхэд, МХОрдын “Эрдэм” медалиар 10 хүүхэд, МСХолбооны “5 онцыг эзэмшигч” медалиар 18 хүүхэд, МЗХолбооны “Тэргүүний сурагч” медалиар 1 хүүхэд, Аймгийн ХТХ-ийн медалиар 145 хүүхэд, нийт 174 хүүхдийг шагнаан урамшууллаа. Мөн олон улс, улсын хэмжээнд урлагаар 6 хүүхэд, сурлагаар 2 хүүхэд, спортоор 15 хүүхэд, эхний 3 байрт нийт 23 хүүхэд шалгарч амжилт гаргаж улсын “Оны шилдэг хүүхэд”-ээр 2 хүүхэд шалгарлаа.

10 аян, 4 хөдөлгөөн, 4 зөвлөгөөн, 2 чуулган, 3 хэлэлцүүлгийг төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран зохион байгууллаа. Аян, хөдөлгөөн, хэлэлцүүлэг, чуулган, сургалт, нээлттэй хаалганы өдрөөр нийт 154 ажил зохион байгуулан, давхардсан тоогоор 18600 хүүхэд, 6138 насанд хүрэгчдэд сургалт, мэдээлэл хийж үйл ажиллагаанд хамруулан, 1560 хүүхдийг уралдаан тэмцээнд хамруулан нийт 7 сая 500 мянган төгрөгийг зарцууллаа.

“Тогтвортой амьжиргаа-2” төсөл: “Олон нийтийн санаачлагын сан бүрэлдэхүүн” хэсгээр нийт 27 төсөлд 146.3 сая төгрөг, бэлчээрийн мал аж ахуйн эрсдэлийн удирдлагын сангийн 57 төсөлд 153.8 сая төгрөгийн санхүүжилт хийгдсэн байна. Есөнбулаг сумд иргэдийн дунд хандив цуглуулах хонжворт сугалаа явуулж 350.0 мянган төгрөгийг цуглуулж тус сумын Тогтвортой амьжиргаа төслийн дансанд тушаасан байна. Уг төслөөр 2012 онд хэрэгжүүлэх төслийн санал авах хурлыг хөдөөгийн 77 багт зохион байгууллаа. 2012 онд олон нийтийн санаачлагын сангаас 18 сумд 202.5 сая төгрөгийн хөрөнгийг хуваарилах боллоо.

Дэлхийн зөн: Эрүүл мэнд төсөлд 108.0 сая, боловсрол төсөлд 110.0 сая, иргэний нийгмийн төслийн хүрээнд 63.0 сая, эдийн засгийн хүрээнд 175.0 сая, нийт 456.0 сая төгрөгийн төсөл хэрэгжүүлсэн байна.

Ардын Дуу Бүжгийн “Алтай” чуулга: Чуулгын тайзнаа нийтдээ 116 тоглолт тоглогдсоноос өөрийн уран бүтээлчдийн 37, гадны уран бүтээлчдийн болон хамтын ажиллагааны 13, кино 66 удаа гарчээ. Нийт 19.5 сая төгрөгийн орлоготой ажиллаж, 37.2 мянган үзэгчдэд урлагаар үйлчилсэн байна.

Аймгийн Музей: Онцгой болон түүх дурсгал, эд өлгийн 2.5 мянган нэрийн үзмэрээр 4,3 мянган үзэгчдэд үйлчилж 1.5 сая төгрөгийн орлоготой ажиллав.

Номын сан: Аймгийн номын сан номын фондоо нөхөн бүрдүүлэлтээр 84 ширхэг ном, 422 шинэ ном, 200 ширхэг хандивийн ном авч нэмэгдүүлэн улирал бүр 10-15 нэр төрлийн тогтмол хэвлэл захиалан уншигчдад үйлчилжээ. Давхардсан тоогоор 20.0 мянган уншигчдад 40.0 мянган ном олгон үйлчилж, зөөврийн сан бий болгон 15 байгууллагатай гэрээ хийж, 1000 уншигчийг хамруулсан байна. Мөн интернэт номын сан ажиллуулж 500 уншигчдад үйлчиллээ. Энэ онд нийт 6 соёл, танин мэдэхүйн ажил зохион явуулжээ. Фондын номын 2% буюу 1.0 мянган номыг сэлгэн засаж, 1800 шинэ уншигч бүртгэж, 403 удаа аман болон бичгээр лавлагаа гаргаж үйлчиллээ.

Онцгой байдлын хэлтэс: Галын дуудлаганд 24 удаа гарч, 14.6 мянган айл өрх, 160 объектод урьдчилан сэргийлэх үзлэг шалгалт хийж, илэрсэн зөрчилд 430.0 мянган төгрөгийн торгууль тавин зохих арга хэмжээ авч, 179.6 сая төгрөгийн хөрөнгийг гал түймрээс аварсан байна. Хүмүүсийн болгоомжгүй үйл ажиллагаанаас шалтгаалсан гал түймрийн улмаас 60.9 сая төгрөгийн эд хөрөнгийн хохирол учирлаа. Энэ онд 24 удаагийн гал түймэр гарсны 13 галыг газар дээр нь унтрааж иргэд 5, өөрөө унтарсан 1 тохиолдол гарсан байна.

Гамшгийн мэдээ: Нийт 59 дуудлага ирж 11 дуудлагад шуурхай бүлэг ажилласан байна. Үүнд авто тээврийн осол 2, цасанд боогдсон 5, хүн алга болсон 7, үер усны 3 нийт 17 дуудлагын дагуу очиж ажиллажээ.

Гэмт хэрэг: Энэ онд байгууллага, иргэдийн 221.4 сая төгрөгийн өмч хөрөнгөнд хохирол учруулсан 146 холбогдогчтой 148 гэмт хэрэг гарчээ. Энэ нь өмнөх оноос 26-аар буюу 14.9 хувиар нэмэгдсэн байна. Энэ онд өмнөх оноос санаатай хүн амь, бусад хулгайн хэрэг нэмэгдэж, хэрэгт холбогдогчдын дотор ажилгүй хүмүүс зонхилж байна. Нийт гарсан хэргийн 41.2 хувийг бусдын өмчийг хулгайлах гэмт хэрэг, үүнээс 6.5 хувийг албан газрын хулгай, 62.3 хувийг орон байрны, 14.7 хувийг малын хулгай, 16.5 хувийг бусад хулгайн гэмт хэрэг эзэлж байгаа нь иргэдийн сонор сэрэмж муу байгаатай холбоотой байна. Гарсан нийт гэмт хэргийн 55.4 хувийг Есөнбулаг сумд гарсан хэрэг эзэлж байна. Гэмт хэргийн илрүүлэлт 60.6 хувьтай боллоо. Нийгмийн хэв журам зөрчсөн 9.3 мянган иргэнийг илрүүлэн шалгаж 8.6 мянган иргэнд 51 сая 798.6 мянган төгрөгийн торгуулийн шийтгэл ногдуулсан байна.

Энэ онд 1.6 мянган хүн эрүүлжүүлэгдэж, 0.3 мянган хүн баривчлагдсан нь өнгөрсөн мөн үеэс эрүүлжүүлэгдсэн хүн 123-ээр, баривчлагдсан хүн 88-аар тус тус нэмэгджээ.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба: Энэ онд 365 гүйцэтгэх хуудасны 317.5 сая төгрөгийн төлбөрт шийдвэр гүйцэтгэлийн үйл ажиллагаа явуулж үүнээс 302 гүйцэтгэх хуудасны 260.2 сая төгрөгийн төлбөрийг бодитойгоор биелүүлсэн байна. Мөн 137 тэтгэлэг төлөгчөөс 78.5 сая төгрөгийн тэтгэлэг гаргуулахаас 54.1 сая төгрөгийн тэтгэлгийг бодитойгоор гаргуулсан ба бодит биелэлт 81.9 хувьтай байна.

Мал тооллогын дүн /толгойгоор/

1/5/2012

№	Сумын нэр	2010 оны мал						2011 оны мал					
		Бүгд	Тэмээ	Адуу	Үхэр	Хонь	Ямаа	Бүгд	Тэмээ	Адуу	Үхэр	Хонь	Ямаа
1	Алтай	38382	1713	851	468	6150	29200	45642	1747	980	572	6501	35842
2	Баян уул	78800	1108	2889	1135	29028	44640	110937	1147	3665	1526	39311	65288

3	Бигэр	69906	1268	2041	1895	16106	48596	85813	1280	2451	2241	19061	60780
4	Бугат	57923	1154	1195	499	19188	35887	67622	1171	1517	566	20284	44084
5	Дарив	87138	1144	3406	1340	30764	50484	98830	1114	3933	1434	33734	58615
6	Дэлгэр	95017	996	1885	775	34008	57353	121200	1198	2450	1059	40754	75739
7	Жаргалан	48837	554	1350	807	18024	28102	63767	540	1602	966	20802	39857
8	Тайшир	32456	285	1078	422	11451	19220	44040	278	1323	581	14600	27258
9	Тонхил	109759	429	4273	1288	52328	51441	120156	357	4610	1350	55646	58193
10	Төгрөг	75384	3337	2467	848	24902	43830	87221	3849	2970	920	26998	52484
11	Халиун	105382	2365	3368	1871	29002	68776	129375	2479	4079	2287	34474	86056
12	Хөхморьт	42924	1499	3544	1265	12554	24062	54016	1565	4021	1456	15424	31550
13	Цогт	119191	1677	1774	1644	29209	84887	142166	1689	2334	1888	34421	101834
14	Цээл	71680	1054	1865	769	15193	52799	89481	1069	2279	1002	17241	67890
15	Чандмана	63453	572	1577	548	20523	40233	85004	617	1909	768	27006	54704
16	Шарга	62381	3357	2364	1615	11571	43474	82397	3358	2742	1954	14855	59488
17	Эрдэнэ	96391	1277	1103	296	17819	75896	105586	1181	1272	316	17122	85695
18	Есөнбулаг	60488	555	1720	865	18425	38923	80082	602	2422	1178	23428	52452
	ДҮН	1315492	24344	38750	18350	396245	837803	1613335	25241	46559	22064	461662	1057809

№	Сумын нэр	Харьцуулсан хувь						2010 оноос зөрүү /- + /					
		Бүгд	Тэмээ	Адуу	Үхэр	Хонь	Ямаа	Бүгд	Тэмээ	Адуу	Үхэр	Хонь	Ямаа
1	Алтай	118.9	102.0	115.2	122.2	105.7	122.7	7260	34	129	104	351	6642
2	Баян уул	140.8	103.5	126.9	134.4	135.4	146.3	32137	39	776	391	10283	20648
3	Бигэр	122.8	100.9	120.1	118.3	118.3	125.1	15907	12	410	346	2955	12184
4	Бугат	116.7	101.5	126.9	113.4	105.7	122.8	9699	17	322	67	1096	8197
5	Дарив	113.4	97.4	115.5	107.0	109.7	116.1	11692	-30	527	94	2970	8131
6	Дэлгэр	127.6	120.3	130.0	136.6	119.8	132.1	26183	202	565	284	6746	18386
7	Жаргалан	130.6	97.5	118.7	119.7	115.4	141.8	14930	-14	252	159	2778	11755
8	Тайшир	135.7	97.5	122.7	137.7	127.5	141.8	11584	-7	245	159	3149	8038
9	Тонхил	109.5	83.2	107.9	104.8	106.3	113.1	10397	-72	337	62	3318	6752
10	Төгрөг	115.7	115.3	120.4	108.5	108.4	119.7	11837	512	503	72	2096	8654
11	Халиун	122.8	104.8	121.1	122.2	118.9	125.1	23993	114	711	416	5472	17280
12	Хөхморьт	125.8	104.4	113.5	115.1	122.9	131.1	11092	66	477	191	2870	7488
13	Цогт	119.3	100.7	131.6	114.8	117.8	120.0	22975	12	560	244	5212	16947
14	Цээл	124.8	101.4	122.2	130.3	113.5	128.6	17801	15	414	233	2048	15091
15	Чандмана	134.0	107.9	121.1	140.1	131.6	136.0	21551	45	332	220	6483	14471
16	Шарга	132.1	100.0	116.0	121.0	128.4	136.8	20016	1	378	339	3284	16014
17	Эрдэнэ	109.5	92.5	115.3	106.8	96.1	112.9	9195	-96	169	20	-697	9799
18	Есөнбулаг	132.4	108.5	140.8	136.2	127.2	134.8	19594	47	702	313	5003	13529
	ДҮН	122.6	103.7	120.2	120.2	116.5	126.3	297843	897	7809	3714	65417	220006

Хээлтэгч малын дүн /толгойгоор/

1/5/2012

№	Сумын нэр	2010 оны мал						2011 оны мал					
		бүгд	ингэ	гүү	үнээ	ЭМ хонь	ЭМ ямаа	бүгд	ингэ	гүү	үнээ	ЭМ хонь	ЭМ ямаа
1	Алтай	18896	626	280	226	3056	14708	18471	536	286	261	2775	14613

2	Баян уул	44286	324	1049	608	16707	25598	45146	364	1118	741	16560	26363
3	Бигэр	31456	350	585	801	7319	22401	32792	370	675	960	7682	23105
4	Бугат	29626	315	407	250	10018	18636	27680	348	476	248	8821	17787
5	Дарив	51317	360	1143	651	19106	30057	47113	383	1242	703	17239	27546
6	Дэлгэр	48415	287	641	351	17312	29824	48620	349	746	461	16807	30257
7	Жаргалан	27256	164	398	453	10029	16212	26529	164	432	476	8682	16775
8	Тайшир	18452	118	387	245	6565	11137	18791	105	424	279	6516	11467
9	Тонхил	57134	70	1540	633	27366	27525	52416	65	1583	659	24980	25129
10	Төгрөг	38249	1142	860	384	12883	22980	35068	1248	917	367	11520	21016
11	Халиун	55879	744	1178	946	15239	37772	53806	794	1208	1079	15154	35571
12	Хөхморьт	20598	323	899	527	6379	12470	20783	354	967	569	6226	12667
13	Цогт	59032	536	616	722	13990	43168	59046	552	726	815	14231	42722
14	Цээл	36050	313	649	372	7500	27216	35722	300	692	436	7304	26990
15	Чандмана	30976	214	545	236	10085	19896	33280	206	540	317	10805	21412
16	Шарга	35255	1326	769	819	6858	25483	35777	1401	856	990	6686	25844
17	Эрдэнэ	47260	346	299	137	9152	37326	41101	335	334	132	7064	33236
18	Есөнбулаг	33876	196	582	449	10261	22388	33700	197	720	569	10129	22085
	ДҮН	684013	7754	12827	8810	209825	444797	665841	8071	13942	10062	199181	434585

№	Сумын нэр	Харьцуулсан хувь						2010 оноос зөрүү +/-					
		Бүгд	Тэмээ	Адуу	Үхэр	Хонь	Ямаа	Бүгд	Тэмээ	Адуу	Үхэр	Хонь	Ямаа
1	Алтай	97.8	85.6	102.1	115.5	90.8	99.4	-425	-90	6	35	-281	-95
2	Баян уул	101.9	112.3	106.6	121.9	99.1	103.0	860	40	69	133	-147	765
3	Бигэр	104.2	105.7	115.4	119.9	105.0	103.1	1336	-20	90	159	363	704
4	Бугат	93.4	110.5	117.0	99.2	88.1	95.4	-1946	33	69	-2	-1197	-849
5	Дарив	91.8	106.4	108.7	108.0	90.2	91.6	-4204	23	99	52	-1867	-2511
6	Дэлгэр	100.4	121.6	116.4	131.3	97.1	101.5	205	62	105	110	-505	433
7	Жаргалан	97.3	100.0	108.5	105.1	86.6	103.5	-727	0	34	23	-1347	563
8	Тайшир	101.8	89.0	109.6	113.9	99.3	103.0	339	-13	37	34	-49	330
9	Тонхил	91.7	92.9	102.8	104.1	91.3	91.3	-4718	-5	43	26	-2386	-2396
10	Төгрөг	91.7	109.3	106.6	95.6	89.4	91.5	-3181	106	57	-17	-1363	-1964
11	Халиун	96.3	106.7	102.5	114.1	99.4	94.2	-2073	50	30	133	-85	-2201
12	Хөхморьт	100.9	109.6	107.6	108.0	97.6	101.6	185	31	68	42	-153	197
13	Цогт	100.0	103.0	117.9	112.9	101.7	99.0	14	16	110	93	241	-446
14	Цээл	99.1	95.8	106.6	117.2	97.4	99.2	-328	-13	43	64	-196	-226
15	Чандмана	107.4	96.3	99.1	134.3	107.1	107.6	2304	-8	-5	81	720	1516
16	Шарга	101.5	105.7	111.3	120.9	97.5	101.4	522	75	87	171	-172	361
17	Эрдэнэ	87.0	96.8	111.7	96.4	77.2	89.0	-6159	-11	35	-5	-2088	-4090
18	Есөнбулаг	99.5	100.5	123.7	126.7	98.7	98.6	-176	1	138	120	-132	-303
	ДҮН	97.3	104.1	108.7	114.2	94.9	97.7	-18172	317	1115	1252	-10644	-10212

ТӨЛ БОЙЖИЛТЫН МЭДЭЭ

1/5/2012

	Төллөсөн хээлтэгч						Хорогдсон төл					
	Бүгд	ингэ	гүү	үнээ	эм хонь	эм ямаа	Бүгд	ботго	унага	тугал	хурга	ишиг
1.Алтай	17877	337	228	202	2749	14361	1608	93	103	40	389	983
2.Баян-Уул	42993	113	903	481	15996	25500	678	3	44	14	291	326

3.Бигэр	26651	205	449	571	6199	19227	1165	41	44	13	263	804
4.Бугат	24569	124	343	196	8419	15487	4181	15	89	49	2354	1674
5.Дарив	45218	173	883	478	18777	24907	9649	59	166	98	4476	4850
6.Дэлгэр	47677	188	525	278	17985	28701	1433	28	40	12	546	807
7.Жаргалан	23285	54	215	234	8582	14200	915	20	27	13	406	449
8.Тайшир	18513	60	294	190	6588	11381	252		2		93	157
9.Тонхил	52260	24	1172	505	26289	24270	3274	10	217	64	1367	1616
10.Төгрөг	31601	583	597	256	11199	18966	23	1	6		10	6
11.Халиун	49223	442	849	820	13731	33381	2172	34	115	86	717	1220
12.Хөхморьт	17971	162	751	398	5508	11152	242				48	194
13.Цогт	51986	291	336	454	12594	38311	2751	17	20	28	628	2058
14.Цээл	32856	127	519	330	6378	25502	4328	13	184	63	868	3200
15.Чандмань	29697	129	462	210	9700	19196	552	8	8	7	149	380
16.Шарга	30627	622	625	661	6053	22666	2387	48	50	68	616	1605
17.Эрдэнэ	41396	170	247	107	7749	33123	3583	33	45	10	737	2758
18.Есөнбулаг	33977	100	572	404	10330	22571	897	2	22	13	320	540
ДҮН	618377	3904	9970	6775	194826	402902	40090	425	1182	578	14278	23627
12/31/2010	227271	3085	3382	4120	87588	129096	122741	733	1826	1472	43795	74915

	Бойжсон төл						Бойжилтын хувь					
	Бүгд	ботго	унага	тугал	хурга	ишиг	Бүгд	ботго	унага	тугал	хурга	ишиг
1.Алтай	16269	244	125	162	2360	13378	91.0	72.4	54.8	80.2	85.8	93.2
2.Баян-Уул	42315	110	859	467	15705	25174	98.4	97.3	95.1	97.1	98.2	98.7
3.Бигэр	25486	164	405	558	5936	18423	95.6	80.0	90.2	97.7	95.8	95.8
4.Бугат	20388	109	254	147	6065	13813	83.0	87.9	74.1	75.0	72.0	89.2
5.Дарив	35799	114	717	380	14414	20174	78.8	65.9	81.2	79.5	76.3	80.6
6.Дэлгэр	46689	160	485	266	17568	28210	97.0	85.1	92.4	95.7	97.0	97.2
7.Жаргалан	22427	34	188	221	8188	13796	96.1	63.0	87.4	94.4	95.3	96.8
8.Тайшир	18526	60	292	190	6617	11367	98.7	100.0	99.3	100.0	98.6	98.6
9.Тонхил	49172	14	955	441	25042	22720	93.8	58.3	81.5	87.3	94.8	93.4
10.Төгрөг	31613	582	591	256	11196	18988	99.9	99.8	99.0	100.0	99.9	100.0
11.Халиун	47618	408	734	734	13146	32596	95.6	92.3	86.5	89.5	94.8	96.4
12.Хөхморьт	17755	162	751	398	5470	10974	98.7	100.0	100.0	100.0	99.1	98.3
13.Цогт	49235	274	316	426	11966	36253	94.7	94.2	94.0	93.8	95.0	94.6
14.Цээл	28600	114	335	267	5529	22355	86.9	89.8	64.5	80.9	86.4	87.5
15.Чандмань	29455	121	454	203	9626	19051	98.2	93.8	98.3	96.7	98.5	98.0
16.Шарга	29126	574	575	593	5598	21786	92.4	92.3	92.0	89.7	90.1	93.1
17.Эрдэнэ	37813	137	202	97	7012	30365	91.3	80.6	81.8	90.7	90.5	91.7
18.Есөнбулаг	33080	98	550	391	10010	22031	97.4	98.0	96.2	96.8	96.9	97.6
ДҮН	581366	3479	8788	6197	181448	381454	93.5	89.1	88.1	91.5	92.7	94.2
12/31/2010	104615	2352	1556	2648	43833	54226	46.0	76.2	46.0	64.3	50.0	42.0

ТОМ МАЛЫН ЗҮЙ БУСЫН ХОРОГДЛЫН МЭДЭЭ

1/5/2012

	эзлэх хувь	Бүгд хорогдол						Бүгдээс өвчнөөр хорогдсон						Бүгдээс хорогдсон хээлтэгч					
		Бүгд	тэмээ	адуу	үхэр	хонь	ямаа	Бүгд	тэмээ	адуу	үхэр	хонь	ямаа	Бүгд	ингэ	гүү	үнээ	эм хонь	эм ямаа
1.Алтай	4.77	1832	93	86	91	795	767	0						614	20	23	13	265	293
2.Баян-Уул	0.92	726	5	30	15	272	404	29		7	2	10	10	200	1	5	4	78	112
3.Бигэр	1.69	1178	12	41	53	280	792	119		5	12	35	67	448	4	11	6	129	298
4.Бугат	8.59	4978	26	56	38	1171	3687	0						1575	1	7	5	276	1286
5.Дарив	3.57	3110	21	98	110	1329	1552	0						960	8	22	53	320	557
6.Дэлгэр	1.12	1060	6	8	13	485	548	74			2	32	40	411	4	6	4	150	247
7.Жаргалан	3.24	1584	14	13	13	670	874	117				53	64	481	1	3	4	192	281
8.Тайшир	0.47	151	4	5	2	65	75	0						62	1		1	20	40
9.Тонхил	10.09	11073	2	116	112	1697	9146	1			1			3547		11	5	262	3269
10.Төгрөг	0.01	8				2	6	0						0					
11.Халиун	4.89	5149	20	121	137	1182	3689	593		15	32	122	424	745		21	9	134	581
12.Хөхморьт	7.93	3404	45	47	48	1058	2206	0						790	5	11	14	248	512
13.Цогт	6.34	7555	32	68	65	2160	5230	2					2	1363	16	17	19	506	805
14.Цээл	0.22	157	5	25	3	40	84	91	1	9	1	25	55	90		1	2	30	57
15.Чандмань	1.43	905	7	20	6	298	574	0						60				25	35
16.Шарга	1.94	1212	97	48	59	267	741	8	5		1		2	369	26	28	32	57	226
17.Эрдэнэ	6.67	6428	43	36	15	1726	4608	0						1592	11	7	3	439	1132
18.Есөнбулаг	5.45	3298	6	19	21	843	2409	109	1	3	2	54	49	623		3	4	206	410
ДҮН	4.09	53808	438	837	801	14340	37392	1143	7	39	53	331	713	13930	98	176	178	3337	10141
12/31/2010	29.46	738235	2400	23567	16967	248839	446462	4240	38	158	127	1520	2397	286537	791	7588	6721	104056	167381

ТӨЛЛӨЛТИЙН ХУВЬ, 100 ЭХЭЭС БОЙЖУУЛСАН ТӨЛ

Сумын нэр	Төллөлтийн хувь						100 эхээс бойжуулсан төл					
	бүгд	ингэ	гүү	үнэ э	эм хонь	эм ямаа	бүгд	ботго	унага	тугал	хурга	ишиг
1.Алтай	94.6	53.8	81.4	89.4	90.0	97.6	86	39	45	72	77	91
2.Баян-Уул	97.1	34.9	86.1	79.1	95.7	99.6	96	34	82	77	94	98
3.Бигэр	84.7	58.6	76.8	71.3	84.7	85.8	81	47	69	70	81	82
4.Бугат	82.9	39.4	84.3	78.4	84.0	83.1	69	35	62	59	61	74
5.Дарив	88.1	48.1	77.3	73.4	98.3	82.9	70	32	63	58	75	67
6.Дэлгэр	98.5	65.5	81.9	79.2	103.9	96.2	96	56	76	76	101	95
7.Жаргалан	85.4	32.9	54.0	51.7	85.6	87.6	82	21	47	49	82	85
8.Тайшир	100.3	50.8	76.0	77.6	100.4	102.2	100	51	75	78	101	102
9.Тонхил	91.5	34.3	76.1	79.8	96.1	88.2	86	20	62	70	92	83
10.Төгрөг	82.6	51.1	69.4	66.7	86.9	82.5	83	51	69	67	87	83
11.Халиун	88.1	59.4	72.1	86.7	90.1	88.4	85	55	62	78	86	86
12.Хөхморьт	87.2	50.2	83.5	75.5	86.3	89.4	86	50	84	76	86	88
13.Цогт	88.1	54.3	54.5	62.9	90.0	88.7	83	51	51	59	86	84
14.Цээл	91.1	40.6	80.0	88.7	85.0	93.7	79	36	52	72	74	82
15.Чандмань	95.9	60.3	84.8	89.0	96.2	96.5	95	57	83	86	95	96
16.Шарга	86.9	46.9	81.3	80.7	88.3	88.9	83	43	75	72	82	85
17.Эрдэнэ	87.6	49.1	82.6	78.1	84.7	88.7	80	40	68	71	77	81
18.Есөнбулаг	100.3	51.0	98.3	90.0	100.7	100.8	98	50	95	87	98	98
ДҮН	90.4	50.3	77.7	76.9	92.9	90.6	85	45	69	70	86	86
ӨМҮе	25.0	38.8	17.2	27.5	29.7	22.6	12	30	8	18	15	10

МАЛЫН ХЭЭЛ ХАЯЛТ, СУВАЙРАЛТ

Сумын нэр	Хээл хаялт							сувайралт						
	хувь	Бүгд	ингэ	гүү	үнэ э	хонь	ямаа	хувь	Бүгд	ингэ	гүү	үнээ	хонь	ямаа
1.Алтай	1.68	318	2	10	12	80	214	2.67	504	11	24	35	147	287
2.Баян-Уул	0.02	11	0	4	0	0	7	9.32	4128	4	202	174	1637	2111
3.Бигэр	3.53	1110	0	12	8	81	1009	15.95	5018	13	191	282	1471	3061
4.Бугат	6.22	1843	0	13	0	57	1773	5.91	1752	3	37	22	1616	74
5.Дарив	4.30	2209	0	10	0	27	2172	10.45	5361	12	241	158	1998	2952
6.Дэлгэр	0.57	278	0	8	7	5	258	3.74	1809	14	100	75	138	1482
7.Жаргалан	2.33	635	0	10	11	10	604	12.35	3367	20	157	190	1508	1492
8.Тайшир	0.00	0	0	0	0	0	0	5.35	988	3	113	72	369	431
9.Тонхил	4.74	2708	0	150	20	457	2081	5.79	3308	3	372	103	1603	1227
10.Төгрөг	2.05	783	0	27	11	4	741	12.85	4916	50	231	88	1436	3111
11.Халиун	2.71	1515	2	34	4	201	1274	4.89	2731	17	263	109	1137	1205
12.Хөхморьт	1.35	279	1	12	5	1	260	10.61	2185	15	155	126	834	1055
13.Цогт	7.17	4230	11	67	49	481	3622	9.02	5324	35	198	198	1252	3641
14.Цээл	0.77	279	0	12	3	8	256	8.26	2977	0	137	68	1135	1637
15.Чандмань	2.54	787	0	27	6	210	544	4.88	1512	0	68	44	651	749
16.Шарга	3.39	1196	43	48	64	215	826	12.45	4388	54	160	190	1007	2977
17.Эрдэнэ	13.77	6510	6	38	4	1127	5335	11.78	5569	24	73	14	1181	4277

18.Есөнбулаг	2.44	826	8	15	8	246	549	6.88	2332	1	82	54	762	1433
ДҮН	3.73	2551 7	73	497	212	3210	2152 5	8.50	58169	27 9	2804	2002	19882	33202
ӨМҮе	24.3 3	1663 92	18 6	262 4	116 3	2089 9	1415 20	37.05	253424	44 8	6571	3804	90993	15160 8

Улсын төсвийн зарлагын гүйцэтгэл / мян.төг/

	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь
Нийт зарлагын дүн	25771923.1	25469861.1	98.8
Урсгал зардлын дүн	25771923.1	25469861.1	98.8
1.Бараа, үйлчилгээний зардал	24923295.2	24457898.4	98.1
1.1 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	14408423.0	14193898.5	98.5
Үндсэн цалин	13497761.8	13393380.2	99.2
Гэрээт ажлын цалин	550817.5	435376.7	79.0
Унаа, хоолны хөнгөлөлт	64978.8	100182.8	154.2
Үр дүнгийн урамшуулал	294864.9	264958.8	89.9
1.2 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1503368.2	1476539.6	98.2
Тэтгэвэр тэтгэмжийн даатгалын шимтгэл	1223103.6	1232871.0	100.8
Байгууллагаас төлөх ЭМД-н шимтгэл	280264.6	243668.6	86.9
1.3 Бараа үйлчилгээний бусад зардал	9011504.0	8787460.3	97.5
Татаас ба урсгал шилжүүлэг	848627.9	1011962.7	119.2
Өрх гэрт олгох шилжүүлэг	393498.7	384976.1	97.8
Нэг удаагийн тэтгэмж, урамшуулал	455129.2	626986.6	137.8

Орон нутгийн төсвийн зарлагын гүйцэтгэл/ мян.төг/

	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь
Нийт зарлагын дүн	7625916.1	7454191.1	97.7
Урсгал зардлын дүн	6378257.1	6202358.0	97.2
1.Бараа, үйлчилгээний зардал	6201767.0	6009720.5	96.9
1.1 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2795891.0	2772239.8	99.2
Үндсэн цалин	2488719.7	2498790.0	100.4
Гэрээт ажлын цалин	299978.3	268284.5	89.4
Үр дүнгийн урамшуулал	0.0	0.0	0.0
Унаа, хоолны хөнгөлөлт	7193.0	5165.3	71.8
1.2 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	307548.0	296415.7	96.4
Тэтгэвэр тэтгэмжийн даатгалын шимтгэл	252184.0	254387.4	100.9
Байгууллагаас төлөх ЭМД-н шимтгэл	55364.0	42028.3	75.9
1.3 Бараа үйлчилгээний бусад зардал	3098328.0	2941065.0	94.9
Татаас ба урсгал шилжүүлэг	176490.1	192637.5	109.1
Өрх гэрт олгох шилжүүлэг	123937.2	125842.6	101.5
Нэг удаагийн тэтгэмж, урамшуулал	52552.9	66794.9	127.1
Хөрөнгийн зардал	1247659.0	1251833.1	100.3
Өөрийн хөрөнгөөр санхүүжих хөрөнгө оруулалт	1247659.0	1251833.1	100.3

Төсвийн зарлагын нэгдсэн гүйцэтгэл/ мян.төг/

	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь
Нийт зарлагын дүн	33397839.2	32924052.2	98.6
Урсгал зардлын дүн	32150180.2	31672219.1	98.5
1.Бараа, үйлчилгээний зардал	31125062.2	30467618.9	97.9
1.1 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	17204314.0	16966138.3	98.6
Үндсэн цалин	15986481.5	15892170.2	99.4
Гэрээт ажлын цалин	850795.8	703661.2	82.7
Унаа, хоолны хөнгөлөлт	72171.8	105348.1	146.0
1.2 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1810916.2	1772955.3	97.9
Тэтгэвэр тэтгэмжийн даатгалын шимтгэл	1475287.6	1487258.4	100.8
Байгууллагаас төлөх ЭМД-н шимтгэл	335628.6	285696.9	85.1
1.3 Бараа үйлчилгээний бусад зардал	12109832.0	11728525.3	96.9

Татаас ба урсгал шилжүүлэг	1025118.0	1204600.2	117.5
Өрх гэрт олгох шилжүүлэг	517435.9	510818.7	98.7
Нэг удаагийн тэтгэмж, урамшуулал	507682.1	693781.5	136.7
Хөрөнгийн зардал	1247659.0	1251833.1	0.0
Өөрийн хөрөнгөөр санхүүжих хөрөнгө оруулалт	1247659.0	1251833.1	0.0

АЙМГИЙН ТӨСВИЙН ОРЛОГЫН ГҮЙЦЭТГЭЛ

	мөр	төлөвлөгө ө	гүйцэтгэ л	хув ь
I. ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ОРЛОГО	1	5974423.0	7288228.2	122.0
II. Урсгал орлого	2	5889923.0	7176020.3	121.8
III. Татварын орлого	3	5646007.3	6794705.8	120.3
1, Орлогын албан татвар	4	1746093.1	2036877.2	116.7
1,1 хүн амын орлогын албан татвар	5	1746093.1	2036877.2	116.7
Цалин хөлс, түүнтэй адилтгах оролгын албан татвар	6	1800339.9	2066908.6	114.8
Хувиараа аж ахуй эрхэлсний орлогын албан татвар	7	51295.2	66046.6	128.8
Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, хувиараа эрхлэгч иргэний орлогын албан татвар	8	11095.0	14549.4	131.1
Мал бүхий иргэний орлогын татвар	9	1800.0	7809.6	433.9
Дундын суутгал	10	0.0	0.0	0.0
Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	11	-1734.0	-1734.0	100.0
Татварын буцаан олголт	12	-116703.0	116703.0	100.0
2, Өмчийн татвар	13	68543.7	98714.6	144.0
Үл хөдлөх хөрөнгийн татвар	14	63399.7	91900.2	145.0
Бууны албан татвар	15	5144.0	6814.4	132.5
4, Тусгай зориулалтын орлого	16	256085.9	261036.7	101.9
Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар	17	256085.9	261036.7	101.9
5, Бусад татвар /төлбөр, хураамж/	18	3575284.6	4398077.3	123.0
Улсын тэмдэгтийн хураамж	19	27439.1	41279.7	150.4
Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр	20	996043.9	2390089.2	240.0
Өсөн нэмэгдэх АМ-ын нөөц ашигласны төлбөр	21	643368.9	0.0	0.0
Лицензийн төлбөр	22	1712897.1	1712897.1	100.0
Газрын төлбөр	23	54077.0	54626.0	101.0
Ойгоос мод, түлээ бэлтгэж ашигласны төлбөр	24	7535.0	7061.7	93.7
Ашигт малтмалаас бусад байгалийн баялаг ашиглахад олгох эрхийн зөвшөөрлийн хураамж	25	560.6	257.4	45.9
Агнуурын нөөц ашигласны	26	11820.0	13200.5	111.7
Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	27	85137.0	122219.6	143.6
Рашаан, ус ашигласны төлбөр	28	35226.0	55739.8	158.2
Байгалийн ургамал ашигласны төлбөр	29	1180.0	706.3	59.9
Бусад төлбөр хураамж	30	0.0	0.0	0.0
IV. Татварын бус орлого	31	243915.7	381314.5	156.3
Хувьцааны ноогдол ашиг	32	0.0	0.0	0.0

мян.төг

Хүү, торгуулийн орлого	33	64406.1	146972.6	228.2
Түрээсийн орлого	34	17212.0	9476.8	55.1
Төсөвт газрын өөрийн орлого	35	45278.0	75199.7	166.1
Нэр заагдаагүй бусад орлого	36	117019.6	149665.4	127.9
Ү. Хөрөнгийн орлого	37	84500.0	112207.9	132.8
ҮХЭХ борлуулсаны орлого	38	19500.0	60641.4	311.0
өмч хувьчлалын орлого	39	65000.0	51566.5	79.3
УЛСЫН ТӨВЛӨРСӨН ТӨСВИЙН ОРЛОГО	40	558342.2	589606.1	105.6
аж ахуйн нэгж, байгууллагын орлогын албан татвар	41	30000.0	81804.1	272.7
Дотоодын бараа, үйлчилгээний нэмэгдсэн өртгийн татвар	42	420000.0	430933.6	102.6
Дотоодын архины онцгой албан татвар	43	60000.0	41826.1	69.7
Ашигт малтмал ашигласны төлбөр	44	4500.0	5261.2	0.0
Агаарын бохирдолын төлбөр АТБӨЯ	45	43842.2	29781.1	67.9
ТӨСВИЙН ОРЛОГЫН НИЙТ ДҮН		6532765.2	7877834.3	120.6

**АЖ ҮЙЛДВЭРИЙН НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮН сумаар,оны үнээр GROSS
INDUSTRIAL OUTPUT, by som, at current price**

мян.төг / thous.tug/

Сумд	Som	2010.XII	2011.XII	Дүнд эзлэх хувь Percentage share to total	
				2010	2011
Нийт дүн	Total	11253341.6	13870876.3	100.00	100.00
Алтай	Altai	40230	23262.7	0.36	0.17
Баян-Уул	Bayan-Uul	2140.0	139040.33	0.02	1.00
Бигэр	Biger	65604.7	98199.4	0.58	0.71
Бугат	Bugat	36012.1	27060.6	0.32	0.20
Дарив	Darib	155130.8	254121.6	1.38	1.83
Дэлгэр	Delger	71397	51805.605	0.63	0.37
Жаргалан	Jargalan	1675.0	46888.6	0.00	0.34
Тайшир	Taishir	49323.1	121644.7	0.44	0.88
Тонхил	Tonhil	6697.0	95053.113	0.06	0.69
Төгрөг	Tugrug	30207	79353.983	0.27	0.57
Халиун	Haliun	41424.4	45788.815	0.37	0.33
Хөхморьт	Huhmorit	13280.0	95507.4	0.12	0.69
Цогт	Tsogt	45900	166408	0.41	1.20
